



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ,  
ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-оос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага /цаашид “Зуучлалын байгууллага” гэх/-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт, шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, журам, зааврын хэрэгжилт, учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.

1.2. Хяналт, шалгалт нь зайны болон газар дээрх хяналт, шалгалт гэсэн төрөлтэй байна.

1.3. Холбогдох төрийн байгууллагуудтай хамтран нэгдсэн хяналт, шалгалтыг хийхэд энэ журмыг баримталж болно.

ХОЁР. ЗАЙНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

2.1. Зайны хяналт, шалгалтаар салбарын болон зуучлалын байгууллагын болзошгүй эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

2.2. Зайны хяналт, шалгалт хийх үйл ажиллагаа нь дараах үе шаттай байна:

2.2.1. Зуучлалын байгууллагаас ирүүлбэл зохих тайлан, мэдээг хянаж, үндсэн үйл ажиллагааны болон цаашид үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, санхүү, төлбөрийн чадварт үнэлэлт, дүгнэлт өгөх;

2.2.2. тайлан, мэдээг ирүүлээгүй, ирүүлсэн тайлан, мэдээ нь шаардлага хангаагүй бол тухайн зуучлалын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд шаардлага хангасан тайлан мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардах;

2.2.3. үндсэн үйл ажиллагаа, санхүү төлбөрийн чадварыг нь сайжруулах чиглэлээр хугацаатай үүрэг даалгавар өгөх;

2.2.4. шаардлагатай тохиолдолд нэмэлт тайлбар, мэдээлэл, холбогдох баримт бичгийг шаардах;

2.2.5. шаардлагатай гэж үзвэл зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх саналыг Хорооны холбогдох удирдлагад танилцуулна.

2.3. Зуучлалын байгууллагаас ирүүлсэн тайлан мэдээг хянаж, эрсдэлтэй гэж дүгнэсэн тохиолдолд тайлангийн хариуг цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ.

ГУРАВ. ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

3.1. Газар дээрх хяналт, шалгалтаар зуучлалын байгууллагын үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, журам зааварт нийцэж байгаа эсэхийг газар дээр нь баримтаар тогтоож, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг авна.

3.2. Газар дээрх хяналт, шалгалтын төлөвлөгөө, газар дээрх хяналт, шалгалтын удирдамж /цаашид “Удирдамж” гэх/-ийг Хорооны дарга батална.

3.3 Удирдамжид шалгалтын зорилго, үндэслэл, шалгалтын төрөл, хүрээ, шалгалтад хамрагдах зуучлалын байгууллагын нэр, шалгалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалт эхлэх болон дуусах хугацааг тусгана.

3.4. Газар дээрх хяналт, шалгалтыг үйл ажиллагааны хамрах цар Жүрээгээр нь иж бүрэн, хэсэгчилсэн гэж ангилна.

3.4.1. иж бүрэн хяналт, шалгалтаар баталсан удирдамжийн хүрээнд холбогдох баримт бичигт тулгуурлан зуучлалын байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж, үнэлэлт, дүгнэлт өгнө.

3.4.2. хэсэгчилсэн хяналт, шалгалт нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж үзсэн зуучлалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

3.5. Удирдамжийг шалгалтад хамрагдах зуучлалын байгууллагад танилцуулснаар шалгалтыг эхлүүлнэ.

3.6. Иж бүрэн хяналт, шалгалтад хамрагдах зуучлалын байгууллагаас дараах тайлан мэдээ, холбогдох баримт бичгүүдийг шаардана:

3.6.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт, компанийн дүрэм;

3.6.2. тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг зохицуулсан дотоод дүрэм, журмууд;

3.6.3. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, холбогдох баримт бичиг, удирдлага зохион байгуулалтын талаарх мэдээлэл;

3.6.4. зайны болон газар дээрх хяналт, шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, холбогдох баримт бичиг;

3.6.5. санхүүгийн болон холбогдох тайлан мэдээ;

3.6.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон шийдвэр;

3.6.7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан дотоод хяналтын хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн хэрэгжилт;

3.6.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ, сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн талаарх баримт;

3.6.9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд харилцагчийг таньж мэдэх үүргээ биелүүлсэн талаарх тайлан мэдээ, холбогдох баримт бичиг;

3.6.10. Хорооноос шаардлагатай гэж үзсэн холбогдох бусад баримт бичиг.

3.7. Хэсэгчилсэн хяналт, шалгалтад хамрагдах зуучлалын байгууллагаас удирдамжид заасан баримт бичгийг шаардана.

3.8. Газар дээрх хяналт, шалгалтын тайлан /цаашид “Тайлан” гэх/-г шалгалтад хамрагдсан зуучлалын байгууллагад удирдамжид заасан хугацаанд танилцуулна.

3.9. Тайлантай холбогдуулан хариу шаардсан бол зуучлалын байгууллага тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

3.10. Тайланг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд тайлантай танилцсанаас хойш 10 хоногийн дотор Хорооны Улсын Ерөнхий байцаагчид бичгээр гомдол гаргаж болно.

3.11. Газар дээрх хяналт, шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг шалгалтын ажлын хэсэг шалгаж үнэлэлт, дүгнэлт өгч Хорооны холбогдох удирдлагад танилцуулна.

## ДӨРӨВ. МЭДЭЭ, ТАЙЛАН

4.1. Зуучлалын байгууллага нь эхний хагас жилийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар болон албан бичгээр ирүүлнэ. Үүнд дараах тайлангууд хамаарна:

4.1.1. Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”, “Санхүүгийн тайлангийн А маягт”, “Санхүүгийн тайлангийн Б маягт”-ын дагуу гаргасан санхүүгийн тайлан;

4.1.2. комплаенсийн эрсдэлийн үнэлгээний тайлан /Хавсралт 1/.

4.2. Зуучлалын байгууллага нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд бизнесийн болон бүтцийн эрсдэлийн үнэлгээний тайланг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ. /Хавсралт 2/

4.3. Зуучлалын байгууллага нь дараах мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ:

4.3.1. Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйл ажиллагааны зуучлалын мэдээ /Хавсралт 3/;

4.3.2. Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслүүлэх, түрээслэх, хөлслүүлэх, хөлслөх үйл ажиллагааны зуучлалын мэдээ /Хавсралт 4/;

4.3.3. Үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авч, засварлан борлуулах үйлчилгээний мэдээ /Хавсралт 5/;

4.3.4. Үл хөдлөх эд хөрөнгийн менежментийн үйлчилгээний мэдээ /Хавсралт 6/;

4.3.5. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаанд хамаарах бусад үйлчилгээний мэдээ /Хавсралт 7/;

4.3.6. Мэдээлбэл зохих гүйлгээ, харилцагчийн бүртгэлийн мэдээ /Хавсралт 8/.

4.4. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад тайлан мэдээ.

4.5. Хянан шалгагч нь хариуцсан зуучлалын байгууллагаас ирүүлсэн тайлан, мэдээг хянаж, нэгтгэлийн системд сарын мэдээг дараа сарын сүүлийн өдөр, эхний хагас жилийн мэдээллийг тухайн оны 8 дугаар сарын 30-ны өдөр, жилийн мэдээллийг дараа оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор баталгаажуулалт хийж, зайны болон газар дээрх хяналт, шалгалтын нэгтгэл тайланг гаргана.

## ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 1 дүгээр хавсралт

КОМПАЕНСЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ӨӨ/СС/000

Д/д	Асуулга	Хариулт		
1.1	Танай байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлог, хамрах хүрээнд нийцсэн МУТС эрсдэлийн өөрийн үнэлгээний аргачлалтай юу?	Тийм	Аргачлалыг боловсруулж, батлуулах шатанд явж байгаа	Үгүй
1.2	Танай байгууллага МУТСТ үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг үү?	Тийм	Төлөвлөдөг боловч хэрэгжүүлдэггүй	Үгүй
1.3	Танай байгууллагад эцсийн өмчлөгчийг тогтоох бичигдсэн процедур дараалал байдаг уу?	Тийм	МУТСТ тухай хуулийн холбогдох заалтыг дагаж мөрддөг	Үгүй
1.4	Танай байгууллагад харилцагчийг таньж мэдэх бичигдсэн процедур дараалал байдаг уу?	Тийм	МУТСТ тухай хуулийн холбогдох заалтыг дагаж мөрддөг	Үгүй
1.5	Танай байгууллага үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үндэслэлийг баримтжуулдаг уу?	Тийм	Үйлчилгээ үзүүлэхээс татгалзах тохиолдол байдаггүй	Үгүй
1.6	Танай байгууллага банктай харилцахдаа халхавч банк эсэхийг нягталдаг уу?	Тийм	Үгүй	
1.7	Танай байгууллага шинэ бүтээгдэхүүн, технологи нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа юу?	Тийм	Үгүй	
1.7.1	Тийм бол нэвтрүүлэхээр төлөвлөж буй шинэ бүтээгдэхүүн, технологийн МУТС-д ашиглагдах эрсдэлийн үнэлгээг хийсэн үү?	Тийм	Үгүй	
1.8	Танай байгууллага улс төрд нөлөө бүхий этгээдийн жагсаалт хөтөлдөг үү?	Тийм	Бусад эх үүсвэрээс авдаг	Үгүй
1.9	Танай байгууллага Олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсын жагсаалт хөтөлдөг үү?	Тийм	Бусад эх үүсвэрээс авдаг	Үгүй
1.10	Танай байгууллага үндэсний эрсдэлийн үнэлгээ (ҮЭҮ)-ээр өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн улсын жагсаалтыг хөтөлдөг үү?	Тийм	Бусад эх үүсвэрээс авдаг	Үгүй
1.11	Танай байгууллага харилцагчийг таньж мэдэх шаардлагыг гуравдагч этгээдэд тавьдаг уу?	дотоод бодлого журамд тусгасан	боловсруулж байгаа	Үгүй
1.12	Танай байгууллагад огцом өөрчлөгдсөн их дүнтэй гүйлгээнд тусгайлан хяналт тавих процедур байгаа юу?	Тийм	боловсруулж байгаа	Үгүй

1.13	Танай байгууллагад эдийн засаг, хууль зүйн илт үндэслэлгүй гүйлгээнд тусгайлан хяналт тавих процедур байгаа юу?	Тийм	боловсруулж байгаа	Үгүй
1.14	Танай байгууллагад УТНБЭ-ийн нэр дээр хийсэн гүйлгээнд тусгайлан хяналт тавих процедур байгаа юу?	Тийм	боловсруулж байгаа	Үгүй
1.15	Танай байгууллагад Олон улсын байгууллагаас МУТСТ хяналтын хангалтгүй тогтолцоотой гэж зарлагдсан улсаар дамжуулан хийсэн гүйлгээнд тусгайлан хяналт тавих процедур байгаа юу?	Тийм	боловсруулж байгаа	Үгүй
1.16	Танай байгууллагад хориг арга хэмжээг хэрэгжүүлэх процедур байгаа юу?	Тийм	боловсруулж байгаа	Үгүй
1.17	Тайлант хугацаанд танай байгууллага 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй хэдэн удаагийн хичнээн төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бэ?			
1.18	Танай байгууллагад хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг МУТС-тэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэх, таньж мэдэх процедур байдаг уу?	Тийм	боловсруулж байгаа	Үгүй
1.19	Танай байгууллага цаасан баримт бичиг болон цахим мэдээллийг ямар байдлаар хадгалдаг вэ? (Мэдээлэл гэдэгт харилцагчийн хийсэн гүйлгээ, данс болон харилцагчийн талаар олж авсан мэдээлэл, баримт бичгийн цахим болон биет мэдээллийг хамруулан авч үзнэ)	5 болон түүнээс дээш жилийн хугацаагаар хадгалж байгаа	Аль нэгийг нь тав болон түнээс дээш жилийн хугацаагаар хадгалж байгаа	Хадгалдаггүй
1.20	Танай байгууллагад дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хариуцсан нэгж, албан тушаалтан байдаг уу?	Тийм	Үгүй	
1.21	Танай байгууллага МУТСТ-д чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй юу? (хуулийн 14.4 дэх заалтын 14.4.1-14.4.13-д заасан)	Тийм	Үгүй	
1.22	Танай байгууллага МУТСТ-д чиглэсэн дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй юу? Ямар хугацаанд шинэчилдэг вэ?	Хагас жил тутам	Хөтөлбөрийг хоёр жил тутам шинэчилдэг	Хөтөлбөргүй эсвэл шинэчлээгүй
1.23	Танай байгууллага МУТС-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт, шалгалт хийдэг үү?	Улирал тутам	Жил бүр хяналт, шалгалт хийдэг	Хяналт, шалгалт хийж байгаагүй
1.24	Танай байгууллага хяналт, шалгалтаар тодорхойлсон асуудлыг шийдвэрлэсэн байдлыг хэдэн хувьтай хэрэгжүүлсэн бэ?			

ТАЙЛАН ГАРГАСАН: ...../...../

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 12 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 2 дугаар хавсралт

БИЗНЕСИЙН БОЛОН БҮТЦИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН


ӨӨ/СС/0000

Д/д	Бизнесийн эрсдэлийн үнэлгээ		
1	Үйл ажиллагааны хамрах хүрээ	1	Улаанбаатарт
		2	Үндэсний хэмжээнд
		3	Олон улсын хэмжээнд
2	Харилцагч	1	Монгол улсын иргэн
		2	Гадаадын иргэн
		3	Монгол улсын иргэн болон гадаадын иргэн
3	Улс төрд нөлөө бүхий этгээд /УТНБЭ/ эсвэл тэдгээртэй холбоотой харилцагчид	3	УТНБЭ эсвэл тэдгээртэй холбоотой харилцагч байгаа
		1	УТНБЭ эсвэл тэдгээртэй холбоотой харилцагч байхгүй
4	Итгэмжлэгдсэн төлөөлөгч бүхий харилцагчид	1	Харилцагч эсвэл хуулийн этгээдийг төлөөлж үйлчлүүлдэг итгэмжлэгдсэн төлөөлөгч бүхий харилцагчтай байхгүй
		3	Харилцагч эсвэл хуулийн этгээдийг төлөөлж үйлчлүүлдэг итгэмжлэгдсэн төлөөлөгч бүхий харилцагчтай байхгүй
5	Харилцагчид дах иргэн, хуулийн этгээдийн эзлэх хувь	1	Үйлчүүлэгчийн тоо
		3	Байгууллагын тоо
6	Газар зүйн байршил	1	Улаанбаатар хот
		2	Хөдөө, орон нутаг
		3	Эдийн засгийн чөлөөт бүс
		4	ФАТФ-аас өндөр эрсдэлтэй гэж үзсэн улс
		5	Бусад гадаад улс орнууд
7	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	1	Бэлэн мөнгөөр тооцоо хийдэггүй
		3	Бэлэн мөнгөөр тооцоо хийдэг

8	Түгээлтийн суваг	1	харилцагчтай биечлэн уулздаг бол
		3	харилцагчтай биечлэн уулздаггүй бол
Д/д	Бүтцийн эрсдэлийн үнэлгээ		
1	ААН-ийн эзэмшлийн хэлбэр	1	Хувь хүний эзэмшил
		2	Хуулийн этгээдийн эзэмшил
		3	Гадаадын хөрөнгө оруулалттай
2	Үйл ажиллагаа эрхэлсэн жил	3	1 жил хүртэлх
		2	1-5 жил хүртэлх
		1	5 буюу түүнээс дээш жил
3	Эзэмшигчийн ангилал	1	Монгол
		3	Гадаад
4	Ажилагсдын тоо	1	3-аас доош
		2	5-аас 8 хооронд

ТАЙЛАН ГАРГАСАН: ...../...../

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 3 дугаар хавсралт



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХИЙГ ХУДАЛДАХ,  
ХУДАЛДАН АВАХ, ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУУЧЛАЛЫН МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

№	Харилцагчийн нэр	ҮХХ-н байршил			Талбайн хэмжээ (м2)	Гэрээ			Үнэ /мянган төгрөг/	Компанийн дансаар гэрээний төлбөр орсон эсэх /Тийм, үгүй/	Гэрээний шимтгэл	
		Улс	Аймаг/хот	Сум/дүүрэг		огноо	дугаар	Гэрчилгээний Ү дугаар			Дүн /мянган төгрөг/	Хувь /%/
1												
2												
3												

ТАЙЛАН ГАРГАСАН: ...../...../

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 4 дүгээр хавсралт


ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХИЙГ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ, ТҮРЭЭСЛЭХ, ХӨЛСЛҮҮЛЭХ, ХӨЛСЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗУУЧЛАЛЫН МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

№	Харилцагчийн нэр	Үйл ажиллагааны төрөл /түрээслэх, хөлслөх/	ҮХХ-н байршил			Талбайн хэмжээ (м2)	Гэрээ			Үнэ /мянган төгрөг/	Гэрээний шимтгэл	
			Улс	Аймаг/хот	Сум/дүүрэг		огноо	дугаар	Гэрчилгээний Ү дугаар		Дүн /мянган төгрөг/	Хувь /%/
1												
2												
3												

ТАЙЛАН ГАРГАСАН: ...../...../

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 5 дугаар хавсралт




ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙГ ХУДАЛДАН АВЧ, ЗАСВАРЛАН  
БОРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

№	Харилцагчийн нэр	ҮХХ-н байршил			Талбайн хэмжээ (м2)	ҮХХ худалдан авсан үнэ	Засварын зардал	ҮХХ худалдсан үнэ	ҮХХ худалдан борлуулсан гэрээ		
		Улс	Аймаг/хот	Сум/дүүрэг					огноо	дугаар	Гэрчилгээний Ү дугаар
1											
2											
3											

ТАЙЛАН ГАРГАСАН: ...../...../

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 6 дугаар хавсралт




ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

№	Харилцагчийн нэр	Харилцагчийн харьяалал	Үйлчилгээний товч утга	ҮХХ-н байршил			Талбайн хэмжээ (м2)	Гэрээ			Гэрээний шимтгэл	
				Улс	Аймаг/хот	Сум/дүүрэг		огноо	дугаар	дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Хувь /%/
1												
2												
3												

ТАЙЛАН ГАРГАСАН: ...../...../

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 191 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 7 дугаар хавсралт




ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ХАМААРАХ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

№	Харилцагчийн нэр	Харилцагчийн харьяалал	Үйлчилгээний товч утга	ҮХХ-н байршил			Талбайн хэмжээ (м2)	Гэрээ			Гэрээний шимтгэл	
				Улс	Аймаг/хот	Сум/дүүрэг		огноо	дугаар	дүн /мянган төгрөг/	Дүн /мянган төгрөг/	Хувь /%/
1												
2												
3												

ТАЙЛАН ГАРГАСАН: ...../...../

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 8 дугаар хавсралт



МЭДЭЭЛБЭЛ ЗОХИХ ГҮЙЛГЭЭ, ХАРИЛЦАГЧИЙН  
БҮРТГЭЛИЙН МЭДЭЭ

0000/СС/ӨӨ

№	Хувь хүн/ байгууллагын нэр	Регистрийн дугаар	Гүйлгээний дүн /төгрөг/	Гүйлгээний төрөл* /БМГ, ГТТГ, СГ/	Гүйлгээ хийгдсэн огноо	Валютын төрөл	СМА-д мэдэгдсэн огноо	Харилцагчдын мэдээлэл	
								Харилцагчийн тоо	НҮБАЗ-ийн хориг арга хэмжээний жагсаалттай тулгаж шалгасан харилцагчийн тоо
1									
2									
3									
	Нийт								

Гүйлгээний төрөл\* - БМГ бэлэн мөнгөний гүйлгээ, ГТТГ гадаад төлбөр тооцооны гүйлгээ, СГ сэжигтэй гүйлгээ

ТАЙЛАН ГАРГАСАН: ...../...../